

11 дүгээр ангийн монгол хэл, бичиг, уран зохиолын анги дэвш их шалгалтын материал

Хугацаа: 80 минут

**А хувилбар**

Нийт- 40 оноо

### ТААХАГ

Энэ буурыг "Таахаг" хэмээнэ. Ямагт сүргийнхээ араас таахаг, таахаг алхлан, тайван явдаг энэ лагс том буур сүвлийн вед юу болов гэмээр айхавтар догширдог болжээ. Хүнээр бол зан ааш нь жигтэйхэн эвдэрсэн гэмээр харагдана. Хавьд чоно нохой сүрэгт нь халдаагвй, айл саахалтын бууртай "урцалдаагвй" атал юунд галзуурсан мэт хэдэн ингээ хаа гуягвй хазаж хавиран, ботго тормоо хвртэл борвидох нь халаг хвзvv сунган хаашаа ч хамаагвй элдэж явдаг зантай болчихдог сон билээ?

Үнэндээ гэхэд тvvний зан ааш ингэтлээ гэнэт хувирсныг эзэн нь огт төсөөлж мэдэхгвй бөгөөд гагцхvv "Таахаг"-т үл таалагдах хvний нэг хачирхалтай үйл явдал, ой гутам нялуун үнэр хоёроос уг явдал үүдэлтэйг ч хvmvvс анхаарсангвй.

Өнөө өглөө ч гэсэн буур ижил сүргээ зэлнээс шалав холдуулая гэсэн мэт, vнсэн дээр хөрвөөх гэж явсан ингэ голдуу баахан тэмээгээ буцаан хөөж, бусдыг хэвтрээс нь босгоод хэдгэнэ шиг хэрэн элдсээр бэлчээр тийш туун одвой.

Буур бvхэнд, тэр тусмаа хvний ухааныг ямар нэг хэмжээгээр авсан байж болзошгвй гэгцгээдэг нь эртний Галзуу улаан, Гялбаа хvрэн, Тэнгэр дуут, Их тавхайтын удам -Таахаг нэрт энэ буур еерийн терелх зенгеес л болоод ороогоо орох болоогвй байхад хvч тэнхээгээ бартал ийнхvv догшроход хvрчээ. Үвнээс vзвэл ер тvvнийг зvгээр л нэг буур тедийгөөр ухаарч боломгвй санагдана. Алив эцэг малд байдаг сvрлэг омгорхуу, догшин эзэрхэг зантайгаас гадна тvvнд өших, өмөөрөх, хямрах ааш араншин бий гэдэг нь илэрхий! Чухам vвнийгээ бусад буурнаас тодорхой харуулж чаддаг чанараараа Өргөний говьд гайхагддаг байж ч болзошгвй.

...Тийнхvv Таахаг сүргээ чимх өвс хазуулсангвй шахам хашин хеесеер бага vдийн алдад Хvрэн тойром хvрч, тэндээсээ эргvvлж элдэх замдаа нэгэн хот айлын гадаа хvрч ирлээ. Явдалдаа ядарч сульдсан тэмээд хvнд хөл, лагс биеийнхээ чилээг гарахаар менеехен айлын vнсэн дээр хэвтэж амрах, хөрвөөж "жаргахаар" хошууран цувахад буур ч дургvйлхсэнгвй. Таахаг энэ сацуу хачин жигтэй юм харлаа. Бееренхий цагаанаас (гэрээс) хэдэн хvн гарч ирээд нэгэн тэмээг ноолж эхлэхийг үзэв. Ноос vсийг нь мулзалж авахтай эгээ адилхан хэвтvvлээд татлага дээсээр баглан хvлж, урт хvзvvг нь газартай наалдуулан сунгаж, хэн нэгэн нь ямарваа шовх юмаар (хvmvvс тvvнийг хутга гэнэ) шилэн хvзvv рvv нь дvрээд авсанд жигтэй нялуун vнэр ханхийжээ. Тэмээ босохыг завдан бvх биеэр ендесхийснээ теделгвй хөдлөхөө болихыг буур сайтар харсан аж.

Эвгвй vнэр авсан тэмээд vнсэн дээрээсээ зэрэг дэрхийн босч чих босгон, хамар шуухируулан, бага залуу нь vнс бужигнатал дэвслэх нь vргэн зайлахыг завдан буйн тэмдэг болой. Тийн хэсэг байзнатал мөнөөхөн хүмүүс яах ийхийн завдалгвй нөгөө тэмээний арьсыг хуулж, эхлээд нvцгэн цагаан бөх, дараа нь улаан махыг гаргасанд Таахагийн тэсвэр тэвчээр алдагдан даруй хурдан зайлахаас аргагвй болов.

...Ийм юмыг урьд өмнө үзэх ч аргагвй байжээ. Юу гэвэл монгол хvн ямарваа малыг муулахдаа тvvнийг сүргийн нvднээс нуудаг тэгээд ижил сүргийг бэлчээрт гаргасан хойно эд бад хийдэг заншилтай. Хэрвээ эл хот айлынхан заншил ёс мэддэг сэн бол vнсэн дээрээ тэмээ ирэхэд дав даруй хөөж зайлуулах л байсан биз ээ! Гэтэл тэгсэнгвй.

Таахаг дотор эрхтнээ гулгин гаргахаас наахнуур сүргээ хөөсөөр хот айлаас холдтол өмнөөс нь нөгөө муухай vнэр дахиад л тосон угтлаа. Сүргээ арга буюу эргvvлэхэд хvрэв. Тэгтэл урдаас нь цус, сэвсний нялуун vнэр улам ч хvчтэй цоргив. Тэгэхээр нь сүргээ баруун зvг эргvvлэв. Дахиад л vнэр! Зvvн тийш туулаа. Үнэр! Урагшаа, хойшоо Үнэр!

Буур хэдий тэнхээтэй, бас ухаантай гэгдэх боловч хvн гэгч амьтнаас сүргээ хэрхэн яаж өмгөөлж хамгаалж чадах сан билээ дээ? /С.Надмид "Таахаг" өгүүллэгээс

1. Зохиогчийн дүгнэлтийг өөрийн үзэл бодолтой харьцуулан бичээрэй. Үгийн тоо 80-100, 10 оноо
2. “Үнэндээ гэхэд тvvний зан ааш ингэтлээ гэнэт хувирсныг эзэн нь огт төсөөлж мэдэхгvй бөгөөд гагцхvv “Таахаг”-т vл таалагдах хvний нэг хачирхалтай үйл явдал, ой гутам нялуун үнэр хоёроос уг явдал үүдэлтэйг ч хvmvvc анхаарсангүй.” Өгүүлбэрийг гишүүдээр ялган зурж, бүтцийг тодорхойл. 4 оноо
3. Эхээс үгийн санжсан, хэлзүйжсэн холбоо үгийн жишээ 2,2- ыг бич. 4 оноо
4. Догширдог – үгийг бүтцээр задлан тайларлаж, авианы хувьслыг тодорхойлж, ижил аргаар бүтсэн үгийн жишээ 2-ыг бич. 4 оноо
5. Эхээс алдаатай бичигдсэн 2 үгийг олж, алдааг засаж бич. 2 оноо
6. Эхээс “ядарч” гэх үгтэй ижил дүрмээр бичигдсэн үг 2-г олж бич. 2 оноо
7. Дараах эхийг монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлнэ үү?

.....

.....

.....


.....

.....

.....

.....

.....



8. Дараах хайку шүлгийн утгыг юу гэж тайлбарласан байдаг вэ? Өөрийн мэдрэмж, сэтгэгдэлтэй харьцуулан бичнэ үү. 5 оноо  
Хуучин цөөрөм рүү  
Хөөрхий мэлхий дэвхрэхэд  
Усны чимээ гарав
9. Дэлхийн сонгодог яруу найргийг тухайн улс оронтой нь зөв харгалзуулаарай. 2 оноо
 

А. “Үүлэн зардас”	1. Япон
Б. “Рубай”	2. Иран
В. “Хайку”	3. Энэтхэг
Г. “Сонет”	4. Итали

10. “...Үнэнийг өгүүлэгч тэр үгэнд итгэж хариу өгүүлрүүн: - “Их ноён оо! Хайрлах чинь үнэн бөгөөс мөн төрүүлсэн эцэгт адил” хэмээсэнд Лүгэ ноён баясаад...” аль зохиолын хэсэг вэ?

- А. Эцэг Горио    Б. Нарангэрэл дагины тууж    В. Сүүлчийн хичээл    Г. Махабхарата

11 дүгээр ангийн монгол хэл, бичиг, уран зохиолын анги дэвш их шалгалтын материал

Б Хувилбар

**Нийт- 40 оноо**

**Хугацаа- 80 минут**

**Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.**

Оддын гэрэл нялхран бүдгэрч, зүүн зүгээс тэнгэр өндөрсөөд үүр цайж эхэллээ. Адуучин эр биеийн алжаалыг одоо л мэдэрч, бас мориныхоо зоог амраая уу даа гэж бодоод бараг суганд нь хүртэл толгойгий нь хантайруулан, эр хүний намба заасан буурилхаг аясаар дөрөөгөө суллан, буухад морь нь шилгээв. Намрын аргамаг тарган морины дорвитой шилгээлтэд жийжүү дөрөө даргар хөмөн гөлмөн дээр хан ян хийж, хуучин суран ганзага сарвайн цацагдана. Адуучин эр шилэмдэж, мориндоо тал шагнаад, хөвөнтэй дээлийн нударгыг сэгсэрч зулайгий нь арчвал морь нь хариу талархах мэт уран сайхан хошуугаар мөрий нь нудчив. Тэгээд толгойг сэгнийлгэж, тод яруухан үүрсэнэ. Үүрийн хөх тэнгэрийг цуурайны цэнхэр өнгөөр сүлж буй хүлэг морины тод үүрсэх чимээнд эзний сэтгэл баясан гэгэлзэж, алжаал тайлагдах мэт болно... Одоо “Жигүүр цагаан” үүрсэнэ дээ гэж бодтол үүрийн гозон гэгээ унаар морины янцгаалтаар дуулгавартай нь аргагүй түрхрэлдэн сэрж байсан их адууны захад хуурын тэвх адил сэгнийн зогссон урт дэлтэй, том биетэй, цагаан азарга үнэхээр үүрсэв. Эзэн инээвхийлснээ :-... Энэ мөн аргагүй сайхан төрсөн амьтан шүү!.. гэж хээр хөдөө ганцаар яваагаа мартчихсан мэт тодоос тод өгүүлэв. Тэгээд цулбуурын үзүүрийг сул атган, хуучин муу булигааран гутлаа өвсөн дунд сар сар хийлгэн чирч хоёр гурав алхаад, доош болсноо эгээ л завилж авлаа.

Шөнөжин морины зоон дээр босоо явсан тэр хүн удалгүй толгойг салаавчлан дээш харж, газар сунайтал хэвтэхэд, жихүүцсэн морь хамраа дуугарган үргэхийв...Тэнгэрт одод, талд адуу, эрийн дотор бодол бэлчинэ. Энэ бол Дагдан байлаа. Ү.Д.Маам “Газар шороо\

1. Дээрх эхийн “ Одоо “Жигүүр цагаан” үүрсэнэ дээ гэж бодтол үүрийн гозон гэгээ унаар морины янцгаалтаар дуулгавартай нь аргагүй түрхрэлдэн сэрж байсан их адууны захад хуурын тэвх адил сэгнийн зогссон урт дэлтэй, том биетэй, цагаан азарга үнэхээр үүрсэв. Эзэн инээвхийлснээ :-... Энэ мөн аргагүй сайхан төрсөн амьтан шүү!.. гэж хээр хөдөө ганцаар яваагаа мартчихсан мэт тодоос тод өгүүлэв” гэсэн хэсгээс ургуулан монгол малчны мал маллах ухааны талаар эргэцүүлсэн эх бичээрэй. Үгийн тоо 100-120, 10 оноо

2. ...Үүрийн хөх тэнгэрийг цуурайны цэнхэр өнгөөр сүлж буй хүлэг морины тод үүрсэх чимээнд эзний сэтгэл баясан гэгэлзэж, алжаал тайлагдах мэт болно... гэх өгүүлбэрийг гишүүдээр ялган зурж, бүтцийг тодорхойлон бич.4 оноо

3. Эхээс дүрслэх ур маяг бүхий хэсгийг олж, тайлбарла. 4 оноо

- .....
- .....

4. Эхэд байгаа “буурилхаг” гэсэн үгийг бүтээврээр задлан тайлбарлаж, ижил бүтэцтэй үг олж бичээрэй. 4 оноо

5. Эхэд ялгах эгшигтэй үг хэд байна вэ? 2 оноо

A. 16                      B.15                      B. 14                      Г. 13

6. Балархай эгшиг гээгдэх үгийг олоорой. 2 оноо

А. Бодчих- оод      Б. Сончих- оод      В. Ганзага-ын      Г. Үнэр- ээр

7. Альфонс Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэгийн Амель багшийн дүрийн зан төрхийг тодорхойлохдоо хэлсэн үг, хийсэн үйлдлийг илэрхийлсэн хэсгийг зохиолоос иш татан дүгнэн бичээрэй. Үгийн тоо 30-40. 5 оноо

8. “Игорийн хорооны үг” туулийн дараах хэсэгт ямар хам сэдэв хөндөгдсөн байна вэ? 2 оноо

...Өнгөрсөн цагин Боян

Өнөр хунгийн сүрэгт                      А. Түүхийн хам сэдэв                      В. Соёлын хам сэдэв

Арван шонхор тавьдаггүй                      Б. Шашны хам сэдэв                      Г. Нийгмийн хам сэдэв

Аялгуут хуурын чавхдасанд

Уран хуруугаа хүргэмэгц

Уянгат тэрхэн чавхдас нь

Ван ноёдын алдрыг

Бадруулан хангинуулдаг сан.

10. Зохиолын үйл явдал өрнөх, дүрүүдийн амьдрах тэр цаг үеийн нөхцөл байдал болон дүрүүдийн хоорондын харилцааны уур амьсгалыг тодруулсан байдлыг ..... гэнэ.

А. Гадаад орчин      Б. Хам сэдэв      В. Дотоод орчин      Г. Өгүүлэгдэхүүний бүтэц

11. Дараах эхийг кирил бичигт буулгаарай. \5оноо\

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

